

“УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ ХӨГЖИЛ, АЛБАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ”

Ц. Ганзориг

439 дүгээр хаалттай хорих ангийн
төлөөлөгч, ахлах дэслэгч

Товч утга: Менежментийн тухай ойлголт, менежерийн ажлын манлайлал болон удирдагч хүний оюун ухааны хийгээд удирдах чадвар, өөрийн удирдах, манлайлах чадвараар тухайн байгууллага, албандаа хэрхэн нөлөө үзүүлэх талаар тодорхой тусгасан.

Түлхүүр үг: Байгууллага, менежмент, менежер, удирдагч, манлайлагч, удирдах албан тушаалтны хөгжил, удирдах албан тушаалтын албанд үзүүлэх нөлөөлөл. Ажлын байр, ажилчин, хандлага, удирдах арга барил.

Нэг. Менежментийн тухай ойлголт

Өнөө үед менежментийг тодорхойлохын тулд байгууллагын талаар тодорхой ойлголттой болсон байх шаардлагатай. Байгууллага гэдэг нь зорилгодоо хүрэхийн тулд зохион байгуулагдсан хамтран ажиллаж буй хоёр буюу түүнээс дээш хүмүүний нэгдэл мөн⁶⁴. Байгууллага нь дараах шинж чанартай байдаг. Үүнд:

1. Нөөц
2. Гадаад орчин
3. Хөдөлмөрийн хуваарь
4. Үйлдвэрлэлийн албууд
5. Удирдлагатай байх ёстой.

Удирдлагын зарчим гэдэг нь аливаа үйлдэл хийх, шийдвэр гаргах ажилд зайлшгүй мөрдөх чиг баримтлал, зүй тогтол юм⁶⁵. Зарчмыг Г.Эмерсон, А.Файоль, Фредрих Тейлор, М.Вебер нар өөр өөрийн үүднээс тайлбарласан байдаг.

Байгууллагын дотоод ба гадаад орчны нөлөөлөл.

Гадаад орчны нөлөөлөлд: шууд бус нөлөөллийн, шууд нөлөөллийн буюу үйлдвэрлэл, өрсөлдөөний гэх 2 орчноос бүрдэнэ. Гадаад орчны шууд бус нөлөөллийн орчинд:

- Эдийн засаг,
- Хүн ам зүй
- Технологи

⁶⁴ Мөнхжаргал. Б. Менежмент. УБ., 2015. 13 дахь тал

⁶⁵ Сумьяабаатар. Б. Удирдахуйн ухаан. УБ., 2013. 13 дахь тал

- Нийгэм соёл
 - Улс төр
 - Хууль эрх зүй багтана.
- Байгууллагын дотоод орчинд
- Эрхэм зорилго
 - Зорилт
 - Бүтэц зохион байгуулалт
 - Хүний нөөц
 - Технологи зэрэг багтана.

Менежментийн үйл явцыг нэн тэргүүний хариуцлага болгон хэрэгжүүлдэг аливаа хүнийг менежер гэнэ. Өөрөөр хэлбэл байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангуулахын тулд өдөр тутам хийж хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээг удирдаж буй удирдлагыг хэлж байна гэсэн үг.

Байгууллагын удирдлага буюу менежерийн талаар товч авч үзвэл.

Менежерийн ажил байгууллагын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхэд бүх хүмүүсийн хүчийг нэгтгэн зохион байгуулах чадвараас хамаардаг. Менежер хүн аливаа бизнесийн болон нийгмийн зорилтыг биелүүлэхийн тулд тухайн ажлыг зохион байгуулах, удирдаж чиглүүлэхтэй холбогдсон олон талын өргөн хүрээтэй онол практикийн мэдлэг, сурган, сэтгэл зүйн ухаан, хүнтэй ажиллах арга хэрэгслийг эзэмшсэн байх хэрэгтэй⁶⁶.

Тийм ч учраас байгууллагын удирдагч буюу менежер нь бүх талын мэдлэг, ур чадварыг өөртөө шингээсэн чадвартай байх мөн байгууллагын ажилтан нарыг идэвхжүүлэх байгууллагын төлөө бүхий чадлаараа ажиллаж байх ажилтанг бэлтгэхийн тулд мэдрэмжтэй мэдлэгтэй байх явдал юм. Менежер хүн өдөр бүр хөгжиж өөрийгөө хөгжүүлж байх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Менежерийн ур чадварт дараах ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай ба судлаач миний бодлоор эдгээр чадваруудаас гадна тухайн байгууллагыг хөгжүүлэхийн тулд төрөл бүрийн чадварт суралцаж цаг тухай бүр хөгжиж байх нь менежер хүнд байх зайлшгүй зан чанар юм. Өөрөөр хэлбэл шургуу байдал ч гэсэн байгууллагын удирдлагад байх нэг зан чанар юм.

1. Техникийн ур чадвар
2. Харилцааны ур чадвар
3. Сэтгэлгээний ур чадвар
4. Хүнтэй ажиллах ур чадвар
5. Шийдвэр гаргах ур чадварууд юм.

⁶⁶ Сумьяабаатар. Б. Удирдахуйн ухаан. Уб., 2013. 15 дахь тал

Байгууллагын хэвийн ажиллах, оршин тогтнох явдал нь гагцхүү байгууллагын менежерээс шалтгаалаад тогтохгүй ажилчдын ажлын байр, ажиллах нөхцөл, сэтгэл ханамж, ажилдаа хандах хандлага, ажилчдыг хэрхэн удирдаж байгаагаас ихээхэн шалтгаалан гэж үзэж байна.

Ажилтнуудын ажлын ханамжид дараах хүчин зүйлүүд нөлөөлнө. Үүнд:

1. Ажлаа зөв сонгосон эсэх
2. Цалин, хөлс
3. Албан тушаал ахиж дэвших, сурч хөгжих боломж
4. Удирдлага, менежмент
5. Хамт ажиллагсад

Сэтгэл ханамж өндөр байх нь ажилчдын гүйцэтгэлд эергээр нөлөөлдөг учир аль болох өндөрт байлгах нь ашигтай юм. Хувь хүмүүс байгууллагын орчинд ямар ямар үйл хөдлөл, харилцаа, хандлага, зан төлөв гаргаж байгааг сэтгэл ханамжийн судалгаанаас харах боломжтой. Ажилчид хувь хүний зүгээс ажиллаж байгаа байгууллагаасаа юу хүсэн хүлээж байдаг, ямар хэрэгцээгээ байгууллагаас хангуулах бодолтой байдаг болон удирдлагаас юу хүсэж хүлээдэг, хэрхэн яаж өөрсдийгөө үнэлүүлэх хүсэлттэй байгааг мэдэж болно.

Байгууллагын ажилчдын сэтгэл ханамж сайн байхад байгууллагын удирдлага, менежмент чухал нөлөө үзүүлдэг нь дээрх нөхцөлөөс харагдаж байна.

Менежмент гэдэг нь тодорхой зорилгод хүрэхийн тулд нөөцүүдийг үр ашигтай, үр дүнтэй арга замаар төлөвлөх, зохион байгуулах, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл мөн⁶⁷.

Менежментийн үндсэн функцууд нь:

- Төлөвлөлт
- Зохион байгуулалт
- Мотиваци
- Хяналт зэрэг байна.

Дээрхээс харахад менежмент гэдэг нь байгууллагын урдаа тавьсан зорилгодоо хүрэхийн тулд түүнийг удирдаж буй менежерийн удирдлага зохион байгуулалт, ур чадварын нийлбэр цогц юм гэж ойлгож болохоор байна.

⁶⁷ Мөнхжаргал. Б. Менежмент. Уб., 2015. 13 дахь тал

Хоёр. Удирдах албан тушаалтны манлайлал

Манлайлал гэдэг нь нэг хувь тодорхой зорилгод хүрэхийн тулд бусдад нөлөө үзүүлэх үйл ажиллагаа юм. Манлайлах үйл ажиллагаа гэдэг нь бизнесийн байгууллагын дотор бол хамгийн дээд удирдлагын тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэхийн тулд менежер өөрийн удирдлагад байгаа хүмүүстээ нөлөөлөх явдал юм⁶⁸.

Манлайлагч нь албан ёсны болон албан ёсны бус манлайлал гэсэн 2 төрөлтэй байдаг. Албан ёсны манлайлал нь байгууллагын удирдлага /менежер, захирал, эрхлэгч/ байдаг бол албан ёсны бус манлайлал нь байгууллагын ажилтан /хувь хүний чанар, ажлын сайн чанараараа/ байдаг.

“Хүмүүс таны юу хийж байгааг бус яагаад хийж байгааг худалдан авдаг” гэж 2009 онд “Учир шалтгаанаар эхлэх” номыг гаргасан Симон Синек хэлжээ. Уг ном хүмүүс өөрчлөлтийн төлөө хэрхэн урам зориг орж үр дүнтэй манлайлагч болоход нь сургах ерөнхий онолыг дэвшүүлэн тавьсан байна⁶⁹.

Манлайлагч гэдэг нь хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн, ямар нэг албадлага эсвэл захиран тушаах арга хэрэглэлгүй бусдын зан байдалд нөлөөлж чадаж буй хүн мөн.

Манлайллыг бүрэн ойлгохын тулд хүч нөлөөг судлах шаардлагатай ба байгууллагын хүч нөлөөнд дараах нийтлэг 5 хүч үйлчилж байдаг.

1. Шагналын хүч нөлөө
2. Албадлагын хүч нөлөө
3. Үлгэр дуурайллын хүч нөлөө
4. Мэргэшлийн хүч нөлөө
5. Албажсан хүч нөлөө

Манлайллын онцлог шинжүүдээс дурдвал:

- Жолоодох
- Манлайлах тэмүүлэл
- Үнэнч бөгөөд шударга шулуун
- Өөртөө итгэлтэй
- Ухаантай
- Ажлын талаарх мэдлэгтэй
- Гадагш хандлагатай байх шаардлагатай ба тухайн шинжүүдийг манлайлагч нь өөртөө шингээсэн байх ёстой байдаг.

⁶⁸ Сумьяабаатар. Б. Удирдахуйн ухаан. УБ., 2013. 107 дахь тал

⁶⁹ Мөнхжаргал. Б. Менежмент. УБ., 2015. 433 дахь тал

Манлайлагчийн сургалт:

Зарим хүмүүст манлайлагч байх шаардлагатай ур чадвар дутагддаг. Манлайлагчийн сургалт нь өөрийгөө сайн хянаж чаддаг хүмүүст амжилт авч ирж чаддаг нь туршилтаар батлагдсан.

Чадварлаг манлайлагч байхын тулд дараах 9 чанарыг эзэмшсэн байх шаардлагатай ба тухайн 9 чанарыг энд дурдаж байна.

1. Тэд бусдын амжилтаас ч аз жаргалыг олж чаддаг
2. Тэд шинэ туршлагыг эрэлхийлж байдаг
3. Тэд ажил, амьдралын тэнцвэрийн талаар боддоггүй, зөвхөн амьдралын талаар л боддог
4. Тэд бусдыг маш сайн ойлгодог
5. Тэд өөрсдийгөө батлах ямар нэг зүйлтэй байдаг
6. Тэд ажлын долоо хоногт заавал 40 цагаар ажиллахыг зөвшөөрдөггүй
7. Тэд мөнгийг ашиг биш үүрэг хариуцлага гэж хардаг
8. Тэд өөрсдийгөө ухаантай гэж боддоггүй
9. Тэд амжилт нисээд ирдэг ч нэр хүнд, бусдыг хүндлэх байдлаа үргэлж хадгалдаг гэсэн 9 чанарыг манлайлагч хүн өөртөө суулгах хэрэгтэй байдаг.

Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилтны хөгжил, албандаа үзүүлэх нөлөөллийн талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтнууд нь өөрсдийн ажил үүрэг, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангана ажиллах гол чиг үүрэгтэй ажилладаг ба тухайн байгууллагын ажилтан алба хаагч нарыг удирдан зохион байгуулах гол субъект юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон журам, зааварт даргын бүрэн эрх, үйл ажиллагааны талаар хэрхэн тусгасан байдлыг дор авч үзвэл.

2017 оны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлага, түүний бүрэн эрхийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх **байгууллагын удирдах**, гүйцэтгэх албан тушаалтан, шийдвэр гүйцэтгэгч, хорих байгууллагын алба хаагчаас бүрдэнэ⁷⁰.

Хорих ангийн удирдлага буюу даргын хүрээнд:

⁷⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль(2017)

272.2.Хорих анги, түүнийг харьяалах шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга нь энэ хуулийн 272.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

272.2.1.хорих анги, байгууллагын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, тушаал, шийдвэр гаргах, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

272.2.2.хоригдлыг хорих ялаас өвчний учир чөлөөлүүлэх тухай саналаа прокурорт гаргах;

272.2.3.хоригдолд чөлөө олгох;

272.2.4.хоригдолд шагналын хоног олгох, хасах;

272.2.5.хуурамчаар, эсхүл санаатай өвчилсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулж эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, чөлөөнөөс хоцорсон, оргосон хугацааг ял эдэлсэн хугацаанаас хасаж тооцох;

272.2.6.хоригдлын хүсэлтийг үндэслэн удаан хугацааны уулзалтыг түр уулзалтаар, эсхүл утсаар ярих эрхээр, эсхүл түр уулзалтыг утсаар ярих эрхээр солих;

272.2.7.Иргэний хуульд заасны дагуу хоригдлын итгэмжлэлийг гэрчлэх;

272.2.8.хуульд заасан бусад бүрэн эрхийг зааж өгсөн байна.

Тэгвэл хорих ангийн харуул хамгаалалтын журамд:

7.2. Хорих ангийн дарга нь хуулиар тогтоосон үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ харуул хамгаалалтад дараах байдлаар хяналт тавьж, удирдан зохион байгуулна.

7.2.1. Холбогдох хууль энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих.

7.2.2. Хорих ангийн аюулгүй байдлыг хангахад бусад чиг үүргийг хэрэгжүүлж байгаа алба хаагчдын үйл ажиллагааг уялдуулан, нэгтгэн зохион байгуулах.

7.2.3. Хамгаалалтын ажилтны хүний нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай галт зэвсэг хэрэглэл, тусгай хамгаалах болон холбооны хэрэгслээр нөхөн хангах саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх.

7.2.4. Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх хуваарийг батлах

7.2.5. Хууль, журмын хэрэгжилт, алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтийг 7 хоног бүрд өдрийн цагт 2-оос, сар бүр шөнийн цагт 1-ээс доошгүй удаа биечлэн шалгах

7.2.6. Хамгаалалтын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.

7.2.7. Жижүүрийн бүрэлдэхүүний ажиллах нөхцөл, тэдэнд олгож буй хоол хүнсний хангалтад хяналт тавьж, сайжруулах арга хэмжээг авах.

7.2.8. Албаны бэлэн байдалд шаардагдах санхүү, хангалт, шатах, тослох материалын нөөцийг бүрдүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах гэсэн ажил үүргийг үйл ажиллагаандаа хийж хэрэгжүүлэхийг⁷¹ хууль болон журамд тус тус зааж өгсөн байна.

Дээр дурдсан хууль болон журамд заасан үндсэн чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги байгууллагуудын удирдлага, менежерүүд нь ажил албан үүрэгтээ мөрдлөг болгон ажиллах нь чухал бөгөөд тухайн ажил арга хэмжээнүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон биелэлтийг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар авч үзэх нь удирдагчийн ажлыг шалгах нэг гол шалгуур үзүүлэлт юм. Мөн эдгээр ажил үүргээс гадна менежер хүний манлайлах бусдыг удирдан чиглүүлэх тал дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтнууд ямар түвшний мэдлэгтэй вэ гэсэн асуултад хариулт өгөх шаардлага тулгарч байгаа юм.

Судалгаанаас үзэхэд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, нэгжийн удирдлага, удирдах албан тушаалтан нар нь өөрсдийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, алба хаагчдын хэвийн ажиллах орчныг бүрдүүлэх, тэдний ажилдаа хандах хандлагыг өөрчилж, удирдан чиглүүлэх чадварт байнга суралцаж, манлайлал болон эрдэм мэдлэгийн хувьд байнга хөгжиж байх нь тухайн байгууллагын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах юм.

Удирдагч хүн мэдлэгтэй, чадвартай байж анги байгууллагыг зөв жолоодон удирдах тул манлайлагч, удирдагч хүний зан чанарыг өөртөө агуулсан хүнийг удирдах албан тушаалд дэвшүүлэн томилох шаардлага тулгарч байна.

Удирдах албан тушаалтан хөгжсөнөөр албанд үзүүлэх нөлөөлөл:

1. Удирдлагын зөв манлайлал нь тухайн байгууллагыг тогтвор суурьшилтай байлгахад чухал нөлөө үзүүлнэ.
2. Байгууллагын алба хаагчид албандаа ажиллах хүсэл эрмэлзэлтэй байж, тогтвор суурьшилтай ажиллах шалтгаан болно.
3. Удирдагч хүнийг бусад ажилтан, алба хаагч нар харж үлгэр дуурайлал авдаг болно.
4. Байгууллагын соёлыг бий болгоно.

⁷¹ Хорих ангийн харуул хамгаалалтын журам (2017)

Дүгнэлт

Тийм ч учраас байгууллагын удирдагч буюу менежер нь бүх талын мэдлэг, ур чадварыг өөртөө шингээсэн чадвартай байх мөн байгууллагын ажилтан нарыг идэвхжүүлэх байгууллагын төлөө бүхий чадлаараа ажиллаж байх ажилтныг бэлтгэхийн тулд мэдрэмжтэй мэдлэгтэй байх явдал юм. Менежер хүн өдөр бүр хөгжиж өөрийгөө хөгжүүлж байх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Дээр дурдсан хууль болон журамд заасан үндсэн чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги байгууллагуудын удирдлага, менежерүүд нь ажил албан үүрэгтээ мөрдлөг болгон ажиллах нь чухал бөгөөд тухайн ажил арга хэмжээнүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон биелэлтийг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар авч үзэх нь удирдагчийн ажлыг шалгах нэг гол шалгуур үзүүлэлт юм. Мөн эдгээр ажил үүргээс гадна менежер хүний манлайлах бусдыг удирдан чиглүүлэх тал дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтнууд ямар түвшний мэдлэгтэй вэ гэсэн асуултад хариулт өгөх шаардлага тулгарч байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, нэгжийн удирдлага, удирдах албан тушаалтан нар нь өөрсдийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, алба хаагчдын хэвийн ажиллах орчныг бүрдүүлэх, тэдний ажилдаа хандах хандлагыг өөрчилж, удирдан чиглүүлэх чадварт байнга суралцаж, манлайлал болон эрдэм мэдлэгийн хувьд байнга хөгжиж байх нь тухайн байгууллагын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах юм.

Удирдагч хүн мэдлэгтэй, чадвартай байж анги байгууллагыг зөв жолоодон удирдах тул манлайлагч, удирдагч хүний зан чанарыг өөртөө агуулсан хүнийг удирдах албан тушаалд дэвшүүлэн томилох шаардлага тулгарч байна.

Эх сурвалжийн жагсаалт

Эрх зүйн эх сурвалж

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
2. Хорих ангийн харуул хамгаалалтын журам 2017 он

Ном, сурах бичиг

1. Сумьяабаатар. Б. Удирдахуйн ухаан. УБ, 2013 он
2. Мөнхжаргал. Б. Менежмент. УБ. 2015 он

Бусад эх сурвалж

1. www.legalinfo.com
2. cd.gov.mn